



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2017 оны 12 дугаар сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 12 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 27%-иар буюу 2,262 сая ам.доллараар өсч, 10,536 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 26%-иар буюу 1,284 сая ам.доллараар, импорт 29%-иар буюу 977 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 1,865 сая ам.доллараар давснаар гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 307 сая ам.доллараар өссөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 12 сар			Өөрчлөлт			
	2014	2015	2016	2015/2014		2016/2015		2015	2016	2017	2016/2015		2017/2016	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	11,011	8,467	8,274	(2,544)	-23%	(192)	-2%	8,467	8,274	10,536	(192)	-2%	2,262	27%
Экспорт	5,774	4,669	4,916	(1,105)	-19%	247	5%	4,669	4,916	6,201	247	5%	1,284	26%
Импорт	5,237	3,798	3,358	(1,439)	-27%	(439)	-12%	3,798	3,358	4,335	(439)	-12%	977	29%
Тэнцэл	538	872	1,558	334		686	79%	872	1,558	1,865	686	79%	307	20%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2017 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр 2,051 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 433 сая ам.доллараар өссөн байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 63% буюу 6,681 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 12% буюу 1,284 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 36%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 37%-иар тус тус өссөн байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 15%-иар өссөн, өмнөх сараас 6%-иар тус тус өсөн 1.75-д хүрлээ. Тайлант сард зэс, нүүрс болон ямааны угаасан ноолуурын экспортын үнэ өссөнөөр худалдааны нөхцөл өмнөх сараас сайжирлаа.

Экспорт 2017 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 26%-иар буюу 1,284 сая ам.доллараар өсөв. Экспорт 26.1 нэгж хувийн өсөлтийн 26 нэгж хувийг уул уурхайн түүхий эдийн экспортын өсөлт, 0.1 нэгж хувийг бусад төрлийн экспортын өсөлт тайлбарлаж байна. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 3 нэгж хувиар өссөн бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эзлэх хувь 2 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2015			2016			2017			Δ (2016/2015)			Δ (2017/2016)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
1. Уул уурхай		4,092	88%	4,238	86%		5,519	89%		146	4%	3%	1,280	30%	26%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,478	2,280	49%	1,554	1,606	33%	1,447	1,613	26%	(674)	-30%	-14%	7	0%	0%
1.2. Чулуун нүүрс	14,426	555	12%	25,607	968	20%	32,986	2,256	36%	413	74%	9%	1,288	133%	26%
1.3. Боловсруулаагүй нефть	8,135	387	8%	7,977	336	7%	7,514	374	6%	(52)	-13%	-1%	38	11%	1%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	5,065	227	5%	6,425	261	5%	6,207	310	5%	33	15%	1%	50	19%	1%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	11,343	421	9%	19,169	758	15%	14,548	595	10%	338	80%	7%	(163)	-22%	-3%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	84	102	2%	126	144	3%	118	181	3%	42	41%	1%	37	28%	1%
1.7. Жонш, лейцит, нефелинт	280	65	1%	247	59	1%	319	84	1%	(7)	-10%	0%	26	44%	1%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	5	29	1%	6	26	1%	6	37	1%	(3)	-10%	0%	11	41%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	2	14	0%	1	10	0%	1	8	0%	(4)	-26%	0%	(2)	-20%	0%
1.10. Мөнгө /тонн/	54	10	0%	95	39	1%	0	1	0%	29	1%	1%	(38)	-98%	-1%
1.11. Бусад	53	2	0%	133	31	1%	440	58	1%	30	1836%	1%	27	1%	1%
2. Мал аж ахуй		329	7%	316	6%		379	6%		(13)	-4%	0%	63	20%	1.3%
2.1. Амьд мал, малын мах	5	14	0%	9	19	0%	29	56	1%	5	37%	0%	37	194%	1%
2.2. Арьс, шир	340	33	1%	173	24	0%	306	23	0%	(9)	-26%	0%	(1)	-6%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	9	0%	0	7	0%	0	6	0%	(2)	-26%	0%	(0)	-2%	0%
2.4. Ноолуур	7	252	5%	7	242	5%	8	262	4%	(10)	-4%	0%	20	8%	0%
2.5. Ноос, бусад үс, хялгас	14	21	0%	16	22	0%	19	29	0%	1	5%	0%	7	33%	0%
2.6. Бусад	0	1	0%	1	2	0%	1	2	0%	1	242%	0%	0	13%	0%
3. Газар тариалан		27	1%	24	0%		14	0%		(3)	-12%	0%	(10)	-42%	-0.2%
4. Аж үйлдвэрлэл		219	5%	337	7%		289	5%		118	54%	3%	(49)	-14%	-1.0%
4.1. Хүнс	4	26	1%	9	43	1%	19	77	1%	17	67%	0%	34	80%	1%
4.2. Ноолууран эдлэл	1	25	1%	1	26	1%	1	32	1%	1	3%	0%	7	27%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	10	0%	2	20	0%	3	16	0%	9	94%	0%	(3)	-17%	0%
4.4. Уул уурхай	35	78	2%	31	88	2%	35	108	2%	9	12%	0%	20	23%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	4	0%	0	5	0%	0	1	0%	1	25%	0%	(4)	-77%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	70	1%	1	148	3%	2	47	1%	78	112%	2%	(101)	-68%	-2%
4.7. Бусад	185	6	0%	237	8	0%	300	7	0%	2	36%	0%	(2)	-21%	0%
5. Бусад		2	0%	1	0%		1	0%		(1)	-59%	0%	0	8%	0.0%
Нийт дүн		4,669		4,916			6,201			247	5%		1,284	26%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2017 он

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	211.3	17%	1,069.0	83%	1,280	30%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(119.2)	-1792%	125.9	1892%	6.7	0%
1.2. Чулуун нүүрс	504.7	39%	783.3	61%	1,288	133%
1.3. Боловсруулаагүй нефть	(23.0)	-60%	61.5	160%	38	11%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	(10.9)	-22%	60.6	122%	49.7	19%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	(189.0)	116%	25.7	-16%	(163.3)	-22%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	(12.0)	-32%	49.2	132%	37.2	26%
1.7. Жонш, лейцит, нефелинт	19.0	74%	6.6	26%	25.6	44%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	4.1	38%	6.7	62%	10.8	41%
1.11. Бусад	40.8	150%	(13.6)	-50%	27.1	0%
2. Мал аж ахуй	58.9	94%	3.8	6%	63	20%
2.2. Арьс, шир	9.8	-684%	(11.3)	784%	(1.4)	-6%
2.4. Ноолуур	7.3	36%	12.8	64%	20.1	8%
3. Газар тариалан	(5.0)	50%	(5.1)	50%	(10.1)	-42%
4. Аж үйлдвэрлэл	79.5	-164%	(128.1)	264%	(49)	-14%
5. Бусад	0.1	119%	(0.0)	-19%	0.1	8%
Нийт дүн	345	27%	940	73%	1,284	26%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2017 оны эхний 12 сард экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 345 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 940 сая ам.доллараар тус тус өссөн байна. Уул уурхайн түүхий эдийн экспорт нүүрсний экспортын биет хэмжээ, үнэ өссөнөөс шалтгаалж 1,280 сая ам.доллараар өссөн байна. Харин мал аж, ахуйн түүхий эдийн экспорт үнэ, тоо хэмжээний аль аль нь нэмэгдсэнээс шалтгаалж 63 сая ам.доллараар өсчээ. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөн хэдий ч үнэ буурсанаас шалтгаалж 49 сая ам.доллараар буурсан байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2017 оны 12 дугаар сард 1,266 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 10%-иар өссөн, харин өнгөрсөн сараас 1.20%-иар буурсан байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,834, 72 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 21%-иар өсч, төмрийн хүдэр 10%-иар буурсан бол, өнгөрсөн сараас зэс 0.11%-иар, төмрийн хүдэр 12%-иар тус тус өссөн байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 12 дугаар сард 72 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 32%-иар, өмнөх сараас 2%-иар тус тус өссөн байна.

Импорт 2017 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 29%-иар буюу 977 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангилалаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 16 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 8 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 4 нэгж хувийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 5 нэгж хувиар буурсан бол нефтийн бүтээгдэхүүний эзлэх жин 2 нэгж хувиар өсчээ.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2015			2016			2017			Δ (2016/2015)			Δ (2017/2016)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн	1,101	29%		1,159	35%		1,285	30%		58	5%	2%	127	11%	4%
Түргэн эдэлгээтэй	836	643	17%	823	652	19%	836	733	17%	9	1%	0%	81	12%	2%
Хүнс	377	445	12%	394	453	13%	390	510	12%	8	2%	0%	58	13%	2%
Эм, тэрийн	2	75	2%	2	90	3%	3	95	2%	16	21%	0%	5	5%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	456	123	3%	427	109	3%	443	128	3%	(15)	-12%	0%	19	18%	1%
Удаан эдэлгээтэй	167	459	12%	125	507	15%	199	553	13%	49	11%	1%	45	9%	1%
Гутал, хувцас, цүнх	44	49	1%	44	53	2%	64	64	1%	4	8%	0%	11	21%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба төвөг	69	94	2%	24	97	3%	71	94	2%	3	3%	0%	(3)	-3%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	254	7%	1	294	9%	1	328	8%	41	16%	1%	34	12%	1%
Бусад удаан эдэлгээтэй бараа	53	62	2%	56	63	2%	63	66	2%	1	2%	0%	3	5%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1,447	38%		1,152	34%		1,702	39%	(295)	-20%	-8%		550	48%	16%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	19	757	20%	17	685	20%	27	1,077	25%	(72)	-10%	-2%	393	57%	12%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	113	3%	1	214	6%	1	328	8%	101	90%	3%	115	54%	3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	18	644	17%	16	471	14%	26	749	17%	(173)	-27%	-5%	278	59%	8%
Барилгын материал	1,638	473	12%	691	283	8%	594	441	10%	(190)	-40%	-5%	159	56%	5%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	78	218	6%	53	185	6%	58	183	4%	(33)	-15%	-1%	(2)	-1%	0%
Аж үйлдвэрлэлийн орц	512	13%		508	15%		552	13%	(4)	-1%	0%		44	9%	1%
Хүнсний орц	51	28	1%	191	53	2%	51	22	0%	25	88%	1%	(32)	-60%	-1%
Химийн бүтээгдэхүүн	128	89	2%	129	86	3%	183	107	2%	(3)	-4%	0%	21	24%	1%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	19	16	0%	28	19	1%	49	23	1%	3	16%	0%	4	21%	0%
Цахилгаан эрчим хүч	1	129	3%	1	124	4%	2	136	3%	(5)	-4%	0%	12	10%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	1	0%	2	1	0%	2	1	0%	(0)	-5%	0%	(0)	-30%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	762	248	7%	752	225	7%	839	264	6%	(23)	-9%	-1%	39	17%	1%
Нефтийн бүтээгдэхүүн	1,146	707	19%	1,060	533	16%	1,370	789	18%	(174)	-25%	-5%	256	48%	8%
Дизель түлш	655	377	10%	554	257	8%	805	428	10%	(119)	-32%	-3%	171	66%	5%
АИ-92, АИ-95	361	228	6%	330	165	5%	354	211	5%	(63)	-28%	-2%	46	28%	1%
А-80 болон бусад	131	103	3%	176	111	3%	211	150	3%	8	8%	0%	39	35%	1%
Бусад	20	29	1%	13	6	0%	153	7	0%	(23)	-1%	-1%	1		0%
Нийт дүн	3,798			3,358			4,335			(439)	-12%		977	29%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2017 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	133.0	105%	(6.5)	-5%	127	11%
Түргэн эдэлгээтэй	19.4	24%	61.8	76%	81.2	12%
Удаан эдэлгээтэй	113.6	251%	(68.3)	-151%	45.3	9%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	418.0	76%	131.6	24%	550	48%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	369.3	94%	23.5	6%	392.8	57%
Барилгын материал	50.1	32%	108.8	68%	158.9	56%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	(1.4)	67%	(0.7)	33%	(2.1)	-1%
Аж үйлдвэрлэлийн орц	49.8	(5.8)	(5.8)	(5.8)	44.0	9%
Нефтийн бүтээгдэхүүн	172.3	67%	83.5	33%	255.8	48%
Дизель түлш	133.6	78%	37.1	22%	170.8	66%
АИ-92, АИ-95	13.8	30%	32.2	70%	45.9	28%
А-80 болон бусад	24.9	64%	14.2	36%	39.1	35%
Бусад	6.8	474%	(5.4)	-374%	1.4	0%
Нийт дүн	780	80%	198	20%	977	29%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд баатдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2017 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр импорт нь тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалаж 780 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 198 сая ам.доллараар тус тус өсчээ. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт нь тоо хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалж 127 сая ам.доллараар өсчээ. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 48%-иар өссөн нь тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын хэмжээ 48%-иар өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2017 оны 12 дугаар сард өмнөх сараас 5 хувиар өсч тонн тутамд 648 ам.долларт хүрэв.